



МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН
ТУШААЛ

2024 оны 05 сарын 21 өдөр

Дугаар А/206

Улаанбаатар хот

Арилжаанд оролцох эрх
олгох тухай

Компанийн тухай хуулийн 83 дугаар зүйлийн 83.1, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.1, "Монголын хөрөнгийн бирж" хувьцаат компанийн Дүрмийн 6 дугаар зүйлийн 6.9.3, "Үнэт цаасны арилжаанд оролцох эрх олгох журам"-ын 2 дугаар зүйлийн 2.3.1 дэх заалтууд болон "Тэнгэр капитал ҮЦК" ХХК-ийн 2024 оны 05 дугаар сарын 13-ны өдрийн хүсэлтийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Монголын хөрөнгийн бирж" ХК-ийн гишүүн "Тэнгэр капитал ҮЦК" ХХК-ийн ажилтан Б.Наранцацрал нь ажлаас чөлөөлөгдсөн тул тухайн ажилтны TNGR.BN нэртэй үнэт цаасны арилжаанд оролцох эрхийг хааж, тус компанийн брокер Б.Хангал -т шилжүүлэн олгосугай.
2. Арилжаанд оролцох эрх авсан ажилтанд Монгол Улсын үнэт цаасны зах зээлд мөрдөгдөж буй хууль, тогтоомж, журам, зааврыг үйл ажиллагаандаа чанд мөрдөж, өндөр хариуцлага, ёс зүйтэй ажиллахыг үүрэг болгосугай.
3. Үнэт цаасны арилжааны программд нэвтрэх нэр, нууц үг олгох ажлыг Үйл ажиллагааны газрын Арилжааны алба /Д.Алдармаа/-нд, тушаалын биелэлтэд Хяналт тавьж ажиллахыг Хяналт, зохицуулалтын газрын Хяналт шинжилгээний алба /Ё.Билгүүнтуяа/-нд тус тус даалгасугай.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Ж.ЦОГТБАЯР

+1524030504